



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/433

Булган сум

Сэлэнгэ сумын Дүгрээ нарсанд
ойжуулалт хийх, 30 га талбайг хашаажуулах
ажлын гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 35 дугаар зүйлийн 35.14 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилго бүхий “Тэрбум мод сан”-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд Сэлэнгэ сумын Дүгрээ нарсанд ойжуулалт хийх 30 га талбайг хашаажуулах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу чанарын өндөр түвшинд зохион байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Сэлэнгэ сумын Дүгрээ нарсанд ойжуулалт хийх, 30 га талбайг хашаажуулах ажлыг хууль, тогтоомжийн хүрээнд чанартай гүйцэтгэхийг “Хөвөнтөн ой” ХХК (О.Оюун)-д даалгасугай.

3. Дээрх ажилд шаардагдах 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

